**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 01 сарын 07-ны өдөр Дугаар БА-004/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-уул дүүргийн 23 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой 12 /арван хоёр/ автомашины дулаан зогсоолтой, 16 давхар, 1 блок 126 /нэг зуун хорин зургаан / байр сууц бүхий аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 сарын 13-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/04/15 огноо, 0014810 дугаар, БАЗГ2024/0205

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: BA-23/07

2.3. Захиалагч: “Соргог байгаль” ХХК оноосон нэр, 9011148140 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5222605 регистрийн дугаар, Хаяг:Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг 19-р хороо, Туул гол 81а байр 50 тоот, холбоо барих утас 99880756, цахим шуудан хаяг;sorgog baigal@gmail.com

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Түдэвтэй уул” ХХК оноосон нэр, 9011227063 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5363527 регистрийн дугаар, БУ12-293/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 16-р хороо, 16 хороолол Улаанхуаран,13-84 тоот, холбоо барих утас 88112985, цахим шуудан хаяг; tudevtei.uul@gmail.com

2.5. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Вауин” ХХК оноосон нэр, 9011556055 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5989841 регистрийн дугаар, ЗТ11-367/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Өнөр хотхон 45б 162 тоот, холбоо барих утас 99020285, цахим шуудан хаяг: bauen.arch@gmail.com

2.6. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Өмчлөгч: “Роялхаус констракшн” ХХК оноосон нэр,9011010039 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5034701 регистрийн дугаар, Хаяг:

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,1 дүгээр хороо, Олимп 7/3 8 давхар, холбоо барих утас: 99054105, цахим шуудан хаяг royalhouse@gmail.com;

Ашиглагч: "Хайспийд" ХХК оноосон нэр, 000257395 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5382076 регистрийн дугаар, 36/2017 тусгай зөвшөөрлийн дугаар дулаан түгээх 36/2017, дулаанаар зохицуулалттай хангах 37/2017, 17 хороо , Их Монголын гудамж, Таймскуэр хотхон 508 байр 01 тоот, холбоо барих утас 99101313, цахим шуудан хаяг: info@highspeed.mn

2.7. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой зоорьтой 12 /арван хоёр/ автомашины дулаан зогсоолтой, 16 давхар, 126 /нэг зуун хорин зургаан/ байр сууц бүхий аялал жуулчлалын зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:
Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

ЯНАЛТ Ш... ГА...
Барилга байгуулам... оруула...

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 29 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох … хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

## Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой 12 /арван хоёр/ автомашины дулаан зогсоолтой, 16 давхар, 126 /нэг зуун хорин зургаан/ байр сууц бүхий аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-уул дүүргийн 23 дугаар хороо, “Соргог байгаль” ХХК-ны захиалгатай, зоорьтой 12 /арван хоёр/ автомашины дулаан зогсоолтой, 16 давхар, 126 /нэг зуун хорин зургаан/ байр сууц бүхий аялал жуучлалын зориулалттай барилга

Комиссын дарга: Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч: (Б.Батчимэг)

Нарийн бичгийн дарга: “Соргог байгаль” ХХК-ны Гүйцэтгэх захирал (Т.Отгонбаяр)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар: 639
Огноо: 2023 он 01 сар 07 өдөр
Бүртгэсэн: О. Жигр
УЛААНБААТАР ХОТ ТТМ 584

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 23 ДУГААР ХОРОО, "СОРГОГ БАЙГАЛЬ" ХХК-НЫ ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР, 12 /АРВАН ХОЁР / АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ, 126 БАЙР СУУЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр                                   Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, зоорьтой 16 давхар, 1 блок, 12 /арван хоёр/ автомашины дулаан зогсоолтой, 126 байр сууц, аялал жуулчлалын зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 107 дугаар блокийн 1 дүгээр орцны 2 дугаар давхарын 201 тоотод 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 15:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 17:00 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга — О.Оджаргал
2. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч — Н.Ёндонсамбуу
3. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч — З.Очирпүрэв
4. Барилгын хөгжлийн төв, Норм нормативын хэлтэс, Ахлах мэргэжилтэн — Г.Уртнасан
5. Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл, хяналтын ахлах байцаагч /Дэд хурандаа/ — Б.Мягмаржав
6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер — Д.Болормаа
7. Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архив, Ахлах архивч — Э.Шижиртуяа
8. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Улаанбаатар хотын сүлжээний газар, Ерөнхий инженер — Н.Болор-Эрдэнэ
9. "Титан Грийд" ХХК, цахилгааны ерөнхий инженер — А.Амаржаргал
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Хүртээмжийн үнэлгээний ажилтан — Б.Ганбаатар
11. Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, Холболтын ахлах инженер — Э.Ундрахцогт
12. Ашиглалт хариуцсан байгууллага: "Хайспийд" ХХК ОСНАА контор, инженер — М.Бумзаяа

13. Ерөнхий гүйцэтгэгч: “Түдэвтэй уул” ХХК-ны захирал Б.Шаравнямбуу
14. Захиалагч: “Соргог Байгаль” ХХК-ны захирал Т.Эрдэнэ-Очир
15. Зураг төсөл зохиогч байгууллага: “Вауйн” ХХК-ны гүйцэтгэх захирал Д.Шижир-Эрдэнэ

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, “Соргог байгаль” ХХК-ны захиалгатай, зоорьтой, 16 давхар, 1 блок, 12 /арван хоёр/ автомашины дулаан зогсоолтой, 126 байр сууц, аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийн ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын байцаагч **Н.Ёндонсамбуу :**

- Бетоны лабораторын шинжилгээг үзүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж үзүүлэх.
- Лифт албан шаардлага биелэлтийн хамт үзүүлэх
- Зоорийн давхарыг дуусгах /ус зайлуулах трап,засал/
- Айл өрхүүдийн хаалга мөргөлдөж байгаад тайлбар албан тоот ирүүлж шиидэх
- Нийтийн эзэмшлийн коридорийн цонхонд хязгаарлагч хийх
- Гадна фасадны ажлыг бүрэн дуусгах
- Айл өрхүүдийн хагарсан цонхийг янзлан засах
- Дутуу байгаа айл өрхүүдийн ажлыг бүрэн дуусгах
- Айл өрхүүдийн жижиг өрөөний халаах хэрэгсэл бүрэн дуусгах
- Дээврийн хэсэгт аянгын төмөр бүрэн хийж гүйцээх.
- Цантаж байгаа айл өрхийн тагтны хэсэгт тайлбар албан тоот өгөх
- Гүйцэтгэгч тусгай зөвшөөрөл үзүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Холигч насосны узельд хаягжуулалт, ус зайлуулах трап хийх
- Ус болон халаалтын коллейкторт хаягжуулалт хийх
- Гражыг дулаан алдагдалгүй болгох

- Үнэр гаргагч өндөрлөн дулаалга хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Норм нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан нормачлалын сангийн төлбөр төлөх
- 1-р давхарын үйлчилгээний гадагш гарах шатыг зураг төслийн дагуу гүйцэтгэх
- Пандусны дээврийг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэх
- Гадна тохижилт ногоон байгууламжийг батлагдсан ЕТ дагуу гүйцэтгэх тайлбар гаргах
- Ариун цэврийн өрөөнүүдэд алчуур хатаагч суурьлуулах
- Цонхны тохиргоо, силкон хийх
- Авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээ хийх
- Батлагдсан зураг төслөөс пандусны орц гарц зөрж байгаа тул өөрчлөлтийн зураг төсөл гаргах
- Зоорийн давхарын болон айлуудын дутуу ажлуудыг дуусгах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, /Дэд хурандаа/ **Б.Мягмаржав**:

- Гадна дулаалгын дүгнэлт нөхөж үзүүлэх
- ГК холбох тотго, хомут солих
- Зоорийн давхарын спринклерийн систем шалгах
- Авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, Ус зайлуулах трап хийх
- Галын дохиоллын систем батлагдсан зургийн дагуу хийж гүйцэтгэх
- Үйлчилгээний барилгад гал унтраах анхан шатны багаж зэвсэг хийх.
- ХЛЛК5566: 2020 стандартын дагуу 15,16-р давхарт айлаас гарах хэсгийн хаалга зай хэмжээ алдагдсан.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх алба, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа:**

- Нийслэлийн эрүүл мэндийн газарт ундны усны шинжилгээ өгч дүгнэлт гаргуулах
- 500/24 тоот техникийн нөхцлийн дагуу холбох батлагдсан ажлын зураг үзүүлэх.
- УСУГ-тай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах аж ахуйн гэрээ байгуулах.
- Ажлын зураг
- Далд ажлын акт
- ХМС-нд бүртгэсэн зураг,CD, акт

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архив, Ахлах архивч **Э.Шижиртуяа:**

ХЯНАЛТ
Г
Барилга байгуу
оруу

- Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх, нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Улаанбаатар хотын сүлжээний газар, Ерөнхий инженер **Н.Болор-Эрдэнэ:**

- Р-С 1-98-3-15 худгаас Р-С 1-98-3-16 худаг хоорондын гэмтсэн сувагчлалыг засварлаж МХС ХХК-д шалгуулах
- Теле хяналтын систем зарлан мэлээллэх домофон угсралт суурьлуулалтыг гүйцээж хэвийн ажиллагаанд оруулах
- Давхарын самбар айлын самбаруудыг батлагдсан зургийн дагуу хийж гүйцэтгэх. Давхарын самбар хаягжуулах.
- Дотор холбоо дохиолол угсарсан кампанийн тусгай зөвшөөрөл шалгуулах.
- Айлуудруу харуулж суурилуулсан камерийг шатруу буюу нийтийн эзэмшил хардаг байхаар суурилуулах.
- Зоорийн давхарын кабелийн тавиурыг нийтийн эзэмшлээр өрөө тасалгаа дамжуулахгүй хийж гүйцэтгэх, агааржуулалтын хоолой дээр суурилуулсан кабелийн тавиурыг салгах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Титан грийд” ХХК, Цахилгааны ерөнхий инженер **А. Амаржаргал:**

- Зураг схем самбар шитэнд байрлуулах
- Зураг схемийн дагуу нэр хаяг бичиглэл хийх / бичиглэл байхгүй /
- Аянгын газардуулгын гүйцэтгэл үзүүлэх
- 107-р блок айл өрх ААН-үүдийг борлуулалтын алба болон ашиглалтын албатай гэрээ байгуулах
- 107-р блокын ерөнхий шит болон эд хөрөнгийн актаар хүлээлгэн өгөх.
- Айл бичиг баримтаар хүлээлцэх.
- СӨХ конторын хэрэглээг тусад нь гаргах
- Дутуу ажлаа гүйцээх
- Ажлын зураг баримт бичиг өгөх хүлээлцэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Налуу замын нэг талд нэмж нэг бариул хийх
- Орцны дотор хаалганы босгоны өндөрийг 2,5 см ихгүй болгох
- Цахилгаан шатны мэдээллийг Монгол хэлээр сонгох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтэс, Холболтын ахлах инженер **Э.Ундрахцогт:**

ШАЛГАЛТЫН
АЗАР
амжийг ашиглалта
ах комисс

- Халаах хэрэгслүүдэд термостат винтель суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Зураг төсөл зохиогч байгууллага: "Вауйн" ХХК-ны гүйцэтгэх захирал **Д.Шижир-Эрдэнэ:**

- Тухайлсан саналгүй

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ашиглалт хариуцсан байгууллага: "Хайспийд" ХХК ОСНАА контор инженер **М.Бумзаяа:**

- Шинэ барилга байгууламж хүлээж авах хавсралт материалуудын жагсаалтын дагуу холигч насос, узель, сан, дулаан, ЦБУ-ын тоног төхөөрөмжүүдийн бичиг баримт зураг төсөл хүлээлгэн өгөх
- Айл өрхийн тоолуурын хаягжилт хийлгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ерөнхий гүйцэтгэгч: "Түдэвтэй уул" ХХК-ны захирал **Б.Шаравнямбуу:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Захиалагч байгууллага: "Соргог байгаль" ХХК-ны захирал **Т.Отгонбаяр:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНбД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх
- Дотор заслыг бүрэн дуусгах
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна тохижилтийг хийж хэрэгжүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, “Соргог байгаль” ХХК-ны захиалгатай зоорьтой, 16 давхар, 126 байр сууц, аялал жуулчлалын зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч: (Б.Батчимэг)

9024041846
8314551 СБТ24866

Тэмдэглэл хөтөлсөн:
“Соргог Байгаль” ХХК-ны сантехникийн
Инженер (Д.Одонтуяа)

УЛААНБААТАР ХОТ
СОРГОГ
БАЙГАЛЬ
ХХК
ТТА9801 5222605